

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 1 САРЫН МЭДЭЭ

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Аймгийн итх-ын тэргүүлэгчдийн гуравдугаар хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх тухай, Иргэний зөвлөлийн зарим гишүүдийн ажиллах хугацааг сунгах тухай, “Дорнод аймагт зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021-2023 онд хийх үйл ажиллагааны дэд хөтөлбөр” батлах тухай, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” дэд хөтөлбөр батлах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

Бодлогын хороо хуралдав.

1. Хүнс хөдөө аж ахуйн бодлогын хороо 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хуралдаж 7 асуудлыг хэлэлцлээ.

2. Аймгийн ИТХ -ын Гадаад харилцаа, Аялал жуулчлалын бодлогын хорооны хурлыг цахим болон танхимын зохион байгуулалттайгаар хийв.

- Хурлаар Дорнод аймгийн гадаад харилцааны бодлогын чиглэл, түншлэх улс орон, хотыг сонгох, харилцах, улмаар аялал жуулчлалын хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцыг сонсож хэлэлцэж шийдвэр гаргалаа.

- Хуралд бодлогын хорооны гишүүн, аймгийн ИТХ -ын төлөөлөгч С.Мөнхжаргал, Б.Батэрдэнэ, П.Гэрэлбаатар, Б.Гэрэлт Од, Ш.Гангамөрөн, Лхамдулам, Ж.Цогтбаатар, бодлогын хорооны дарга Р.Зоригтбаатар, ИТХ -ын дарга М.Энхтөр нар оролцов.

Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын Удирдах ажилтнуудын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн шуурхай хуралдааны тэмдэглэлээс:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат цаг үеийн мэдээлэлтэй холбогдуулан дараах үүрэг даалгаврыг өгөв. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оныг “Хувийн хэвшлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Коронавируст халдвар /Covid-19/ цар тахлын үед үүсэж буй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагуудад, дэмжиж ажиллахыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад,

2.Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалны агааржуулалтыг сайжруулах, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, дараагийн тусгаарлах байрны бэлэн байдлыг хангасан тохиолдолд сумын Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд спорт заалны үйл ажиллагааг эхлүүлэхийг сумын Засаг дарга нарт,

3.Засгийн газрын 2021 оны 02, аймгийн Онцгой комиссын 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, Цагаан сарын баярыг нийтээр тэмдэглэхгүй байхыг иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг нийт байгууллагын удирдлагуудад,

4.Худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд сар бүр үнийн судалгаа хийхийг сумын Засаг дарга нарт, татварын Е-баримтад суурилсан QR кодыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглахыг нийт байгууллагын удирдлагуудад,

5.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу сумын Засаг даргын орлогчийг томилохыг холбогдох сумын Засаг дарга нарт, багийн Засаг дарга нар хүндэтгэн үзэх шалтгаанаар ажил үүргээс чөлөө авсан бол үүрэг гүйцэтгэгчийг тухай бүр томилж ажиллуулахыг нийт Сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.

ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийт орлого 6409,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 6605,6 сая төгрөг, үүнээс татварын орлого 1845,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 1739,9 сая төгрөгт хүрч 105,9 сая төгрөгөөр тасарч, татварын бус 4563,9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 4865,7 сая төгрөгт хүрч 301,8 сая тус тус төгрөгөөр давж биеллээ.

Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөөс /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	6,409,771,000.00	6,605,645,793.09	195,874,793.09	103.06
003 ТАТВАРЫН ОРЛОГО	1,845,869,100.00	1,739,931,405.26	(105,937,694.74)	94.26
004 Орлогын албан татвар	1,292,331,500.00	1,310,594,763.43	18,263,263.43	101.41
016 Хөрөнгийн албан татвар	90,736,300.00	88,641,820.92	(2,094,479.08)	97.69
021 Бусад татвар, төлбөр, хураамж	507,288,200.00	401,336,365.86	(105,951,834.14)	79.11
90041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,563,901,900.00	4,865,714,387.83	301,812,487.83	106.61
042 Нийтлэг татварын бус орлого	373,002,900.00	699,743,087.83	326,740,187.83	187.60
049 Хөрөнгийн орлого	0.00	1,375,000.00	1,375,000.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,482,462,500.00	3,482,462,500.00	-	100.0
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,482,462,500.00	3,482,462,500.00	-	100.0
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	0.00	-	#DIV/0!

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 8006,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 4725,8 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%

- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 582,1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 3482,5 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,006,806,200.00	4,725,818,188.12	(3,280,988,011.88)	59.0
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	3,566,753,500.00	2,912,011,993.95	(654,741,506.05)	81.6
Ажиллогччооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	477,835,000.00	374,291,708.13	(103,543,291.87)	78.3
Бараа үйлчилгээний бусад зардал	718,330,700.00	219,408,823.00	(498,921,877.00)	30.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,763,400.00	207,143,959.79	(178,619,440.21)	53.7
Б. ХӨРСНГИЙН ЗАРДАЛ	1,087,427,700.00	91,853,700.00	(995,574,000.00)	8.4

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, www.dornod.gov.mn вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажилласан.

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийн дагуу биелэлтийг 2020 оны байдлаар гаргаж 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн дотор хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн гишүүнээс шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн 3 өргөдлийн дагуу холбогдох хариуг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн харьяан дор “Нэг цонхны үйлчилгээний цэг” нь үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус цэгээр өдөрт 100-120 гаруй хүн үйлчлүүлж, олон хүний бөөгнөрөл ихээр үүсч байгаатай холбогдуулан аймгийн Онцгой комисст хүсэлт хүргүүлэн маск - 200 ширхэг, нүүрний хаалт - 3 ширхэг, гар ариутгагч/санитол/- 3 ширхгийг хүлээлгэж өгч ажилласан.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлыг төлөвлөгөөний дагуу холбогдох хэлтэс, агентлагуудаас авч нэгтгэн Үндэсний байдлын зөвлөлд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлсэн “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээс холбогдох арга хэмжээг авч, бүх сумаас тайлан, мэдээг авч нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Авлигын эсрэг аймгийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөөг боловсруулж, захирамжийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан.

“Жаст-ойл” ХХК-ийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг дээр Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж оролцсон.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны жилийн эцсийн тайланг холбогдох хэлтэс, агентлагуудаас авч нэгтгэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхтэй холбоотой захирамжийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан холбогдох мэргэжлийн байгууллагуудруу able-ээр хүргүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 3 өргөдөл ирүүлснээс 2 өргөдлийг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 3 иргэнээс 2 иргэнд 800,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат,

аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2021 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар ирсэн 4 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 2 тодорхойлолт, 2 албан бичиг боловсруулж явуулсан байна.

2.Баримт ашиглалтын талаар:

1 дүгээр сард 87 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 232 хуулбар, 15 иргэнд 114 оны захиалга хүлээн авч А дансны лавлагаа олгож, 2 тодорхойлолт гаргаж нийт 948 500 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 38 хөмрөгийн 174 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

2021 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс 31-ны өдрийг хүртэлх хүртэлх хугацаанд нийт давхардсан тоогоор 80 байгууллагын 15 төрлийн 35 810 ширхэг хэвлэмэл хуудасны захиалга авч стандартын дагуу хэвлэж, дугаарлан бүртгэл хөтлөн холбогдох байгууллагуудад нь олгоод байна.

Нийт давхардсан тоогоор 80 байгууллагын 3 239 300 төгрөгийн төлбөр орох ёстойгоос 40 байгууллагын 1 661 300 төгрөгийн орлого орсон байна.

Шинээр 2 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

Аймгийн шүүх болон Сэргэлэн сумын түүхт ой болохтой холбоотойгоор судлаач Н. Цогоо, Сэргэлэн сумын иргэн Ч. Батсүх нарын хүсэлтээр 33 болон 132 дугаар хөмрөгөөс нийт 98 хадгаламжийн нэгжийг ашиглуулж холбогдох бүртгэлтийг хөтөлж ажиллаа.

3.Нөхөн бүрдүүлэлт

Улаанбаатар хотын “ДИБИТИБИ” ХХК хийж гүйцэтгэсэн Баяндун сумын 100 хүүхдийн дотуур байрны барилгын ажилд холбогдох 897 хуудас бүхий 24 ХН, Улаанбаатар хотын “Бүрэнсүх” ХХК хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 4 дүгээр багт баригдсан “Элит таун” хотхоны 135 айлын орон сууцны 208 байрны 1 дүгээр ээлжийн барилгын ажилд холбогдох баримт 1459 хуудас бүхий 19 ХН сан хөмрөгөө нөхөн бүрдүүллээ.

4.Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:

2021 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

2021 оны 1 дүгээр сарын 31-ны байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 4 хөмрөгийн 4 дансны 123 хадгаламжийн нэгжийн 10 733 хуудас баримтыг шивж байршуулав.

- Цахим холболт- 123 хадгаламжийн нэгжийн 10 733 хуудас баримт
- Хүний нэр-55637
- Байгууллагын нэр-1031

- Газар зүйн нэр-1440
- Заалт 8269

Хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1980 1982 оны 6 хадгаламжийн нэгжийн 1089 хуудасыг Төрийн архивын программд шивж орууллаа.

5.Зөвлөгөө:

Аймгийн “Их базар констракшн” ХХК, “Сувд шилтгээн” ХХК, “Бүрэн сүх” ХХК ны инженерүүдэд зураг төслийн баримтаар хадгаламжийн нэгж хэрхэн бүрдүүлэх, архивт баримт шилжүүлэх талаар заавар зөвлөгөө өгөв.

6.Бусад:

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 1 дүгээр сарын 7,14,21-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 1 дүгээр сарын 8,15,22-ны өдрүүдэд хөтөлж ажилласан.

Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:
Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Биеийн тамир, спортын газар

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар хуралдаанаар спорт заалуудыг нээх шийдвэрийн дагуу спортын 7 төрлийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургуулилтыг хангах, иргэдэд спорт заалаар үйлчилж эхэлсэн. Заалыг нээхдээ мэргэжлийн байгууллагуудын өгсөн заавар, зөвлөмжийн дагуу халдвар, хамгааллыг чанд мөрдөхийг багш, дасгалжуулагчид, тамирчдад сануулж, хяналт тавих ажилтныг томилон ажиллуулж байна.

2021 оны спорт бэлтгэл сургалтын үйл ажиллагаа явуулах таатай орчинг бүрдүүлэх, байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор ашиглалтад орсноос хойш хийгдээгүй байсан заалны будгийн бүрэн засварыг өөрсдийн хүч, хөрөнгөөр хийж гүйцэтгэн спортын дугуйлан, спортын үйл ажиллагаа болон иргэдэд үйчлэхэд бэлэн боллоо.

Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутагт дэвсгэрт орших хөл хорио дэглэмд орсон айлд хоол хүнсний тусламж үзүүллээ.

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос байгууллагын цахим санг шинэчлэх, хөгжүүлэх чиглэл өгсөн дагуу хийж гүйцэтгэж байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Боловсрол, соёл, урлагийн газар

Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх ажлын хүрээнд:

2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 12 дугаар ангийн 814 сурагчтай цахим уулзалтыг судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтад хэрхэн бэлтгэх, бие даан суралцах боломжтой сайт, апплекейшнуудыг ашиглах талаар зөвлөмж хүргэн, “Дорнод ЭЕШ 2021” групп байршуулсан.

Дорнод аймгаас 430 хүүхэд Англи хэлний хичээлээр шалгалтад орох бөгөөд эдгээр сурагчдын бэлтгэлийг чанаржуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор Дорнод “ЭЕШ 2021” фэйсбүүк бүлгэмд өдөр бүр хичээл зааж байна.

Хичээлийг боломжтой үедээ ухрааж үзэн, 3 удаагийн явцын шалгалтад хамрагдаж, дүнд анализ хийн ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч, мэргэжлийн багш нараас 10 судлагдахуунаар онлайн сорил авч, давхардсан тоогоор 2337 шалгуулагч

шалгагдаж, шалгалтын анализ, тайлбарыг багш, сурагчдад хүргэх ажлыг судлагдахуун хариуцсан мэргэжилтэн болон тэргүүлэх багш нар хүргэн, “Дорнод ЭЕШ 2021” групп хичээл бүрээр багш нар лайв хичээл зохион байгуулсан.

Ном, гарын авлага:

Багш нарыг чиглүүлэгч, зөвлөн туслагч, багшийн багш болсон бага боловсролын сургалтын менежерүүдийн сайн туршлагыг нийтэд сурталчилж, тэдний амжилтаар бахархан хүргэхээр “Сургалтын менежерийн туршлага-Миний брэнд санаа” эмхэтгэлийг засан сайжруулан ажиллаж байна.

Математик, хүн ба орчин, хүн ба байгаль, хүн ба нийгэм, дүрслэх, урлаг технологийн хичээлээр ЕБС-ийн 20 сургуулийн багш нарын даалгаврыг засан сайжруулах зөвлөгөөг өгч, эмхэтгэл болгохоор 4 сарын хугацаанд 3 эксперт, 3 хянагчтай хамтран ажиллаж байна. Одоогоор эмхэтгэлийн явц 70 хувьтай.

Ололт, амжилт:

“Aplus” технологийн дэвшлийг ашиглан Дорнод аймгаас 22 багш үндэсний хэмжээнд хичээл зааж, арга зүйгээ түгээн дэлгэрүүлж байна.

Орон нутгийн “Мижи” телевизээр 10 судлагдахуунаар теле хичээл бэлтгэн ахлах ангийн сурагчдад өдөр бүр хүргэж байна.

Цахим хурал, уулзалт:

2020-2021 оны хичээлийн жилд 12 дугаар ангид хичээл зааж буй 10 судлагдахууны 160 багштай онлайн уулзалт зохион байгуулж, зөвлөмж, чиглэл өгсөн.

“<https://www.socrative.com/> сайтыг ашиглах арга” сэдвээр Цагаан-Овоо сумын Монгол хэл-Уран зохиолын багш Б.Содцэцэг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр сургуулийнхаа 18 багш, монгол хэл, бичгийн 61 багшид сургалт зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсролын салбарын тайлан мэдээлэл, гарсан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн цахим онлайн хэлэлцүүлэг зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн эрхлэгч 35, арга зүйч 31, нийт 66 хүн оролцов.

Боловсрол, соёл урлагийн газар Хан-Уул цоцголбор сургуультай хамтран 2021.01 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Түүх, Нийгэм, Англи хэл, Биологи, Физикийн 120 багшид “Судлагдахууны чиглэлээр заах арга зүйг дээшлүүлэх” онлайн сургалт зохион байгуулсан.

Математикийн судлагдахууны “Тэргүүлэх” зэрэгтэй 8 багш онлайнар мэргэжлийн багш нарт сургалт зохион байгуулсан. Монгол хэл, бичгийн багш нарын

заах аргын нэгдлийн ажлаар 58 багш хамрагдан, сайн туршлага, арга зүйгээс суралцав.

Дэлхий нийтийн ногоон хөгжил Тогтвортой хөгжлийн боловсрол Олон улсын “ЭКО” хөтөлбөрт шинээр элсч, Хэрлэн сумын 1, 2, 11, 14, 15 дугаар цэцэрлэгийн удирдах ажилтан, багш, туслах багш 25 хүн 2021 оны 01 дүгээр сарын 18-20 ны өдрүүдэд цахимаар хамрагдсан.

Ерөнхий боловсролын 26 сургууль, 36 цэцэрлэгт БШУЯ-аас ирүүлсэн БШУ-ны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/24 дүгээр “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” тушаалыг хүргүүлж, сургууль, цэцэрлэгүүд 2 дугаар улирлын сургалтын үйл ажиллагааг цахимаар бэлтгэлээ хангаж байна.

Соёлын үйл ажиллагаа:

“Үл бүдгэрэх их өв” цахим сургалтаар бэлтгэгдсэн сургагч багш нарын орон нутаг, тухайн байгууллага дээрээ түгээнд дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан 18 байгууллагын 32 удаагийн сургалтад зочин багшаар ахлах мэргэжилтэн Л.Идэрбат уригдан оролцсон.

Үндэсний хэмжээнд зохион байгуулж байгаа Боловсролын хүрээлэнгийн судлагдахууны цахим сургалтад 2 удаа хамрагдсан.

Орон нутгийн зохион байгуулалтаар төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Удирлагын академийн 1 сарын сургалтад хамрагдаж байна.

Аймгийн хөгжмийн боловсролын багш нарын мэргэжлийн зөвлөл байгуулах тухай судлагдахууны багш нартай цахим 3 удаагийн хурал зохион байгуулж мэргэжлийн зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй өргөжүүлэн хамтран ажиллаж байна.

“Аман өвийн уламжлалыг хөгжүүлэх, уламжлуулан хөгжүүлэх арга зам” сэдэвт цахим сургалтын бэлтгэл ажлыг хангах, удирамж, төлөвлөгөө боловсруулах, хамтран ажиллах төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудыг оролцуулах, хамтын ажиллагааг төлөвлөн ажилласан.

Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 9 дуудлага, 2 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Шийдвэрлэлт 90 хувьтай. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө”-гөөр нийт 15 хүүхэд, 3 насанд хүрэгчид давтамжтай зөвлөгөө

үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард бэлгийн хүчирхийллийн хохирогч 3 хүүхдийг хамгаалан байрлуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлж, харъяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлсэн.

Насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэгт холбогдсон 5 хүүхдийн байцаалтанд оролцож, хүүхдийн эрхийг ханган Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үрчлэлтийн дүгнэлт гаргуулах саналын хүрээнд 4 өрхөд үнэлгээ хийж, дүгнэлтийг хүргүүлсэн. Гэр бүл цуцлалт, хүүхдийн асран хамгаалагч тогтоох асуудлаар 3 өрхтэй ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргасан.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:

Шинэ коронавирус /Covid-19/ цар тахлын улмаас улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор “Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн шуурхай штаб”-ыг ажиллуулан албан хаагчид хуваарийн дагуу ажиллаж, 7058-4455 шуурхай утас болон Хүүхдийн тусламжийн 108 утсанд 20 дуудлага мэдээллийг хүлээн авч, нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт гарган, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлсэн. Мөн Улаанбаатар хотоос ирж, тусгаарлалтанд байгаа насанд хүрээгүй нийт 7 хүүхдийг хяналтад авч, өдөр бүр холбогдон хяналт тавьж байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар хуралдааны шийдвэрээр мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн халдвар хамгаалалтын дэглэмийн шаардлага хангасан Төгөлдөр хуур, хятад хэл, шатрын дугуйлангууд 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Дугуйлан бүр хүүхэд бүрийн халууныг хэмжиж, бүртгэл хөтлөн нэг ээлжинд 5 хүүхэдтэйгээр хичээллэж байна.

Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн чиглэлийн дагуу “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 10 хавсралт маягтын дагуу хөтөлбөрийн биелэлт, хүйс, жендэрийн судалгааны маягтуудыг тус бүр гарган нэгтгэж, судалгаануудыг үндэсний статистикийн 1212.mn сайтад байршуулав.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучууддаа тогтмол зохион байгуулж байна. Цуврал сургалтын хүрээнд “Харилцаа хандлага, Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, Стрессийг зохицуулах, өөртөө итгэх итгэл, Төлөвлөлт” сэдвээр 1 байгууллагын нийт 22 ажилтан, албан хаагч, сурагчдад сургалт зохион байгуулахаас гадна хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй насанд хүрээгүй 2 иргэнд, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж байгаа 3 охидод тус тус цахимаар зохион байгуулав.

Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг

Нийгмийн даатгалын хэлтэс

Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын санд 2021 оны 01 дүгээр сард 2162245,8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2201895,29 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 101,8 хувиар биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас тэтгэврийн санд нийт 3400000,0 мянган төгрөгийн, тэтгэмжийн санд нийт 100000,0 мянган төгрөгийн, ажилгүйдлийн санд нийт 70000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан.

2021 оны 01 дүгээр сард нийт 613 ажил олгогч байгууллагын 4799 даатгуулагчийн 84058,1 мянган төгрөг, 4458 сайн дурын даатгуулагчдын 16952,0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (Тэтгэврийн даатгалын 9,5 хувь, Эрүүл мэндийн даатгалын 2 хувын шимтгэлээс бусад) тус тус чөлөөлсөн байна.

Хоёр. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сард шинээр нийт 152 иргэнд тэтгэвэр тогтоов. Түүнчлэн 2021 оны 01 дүгээр сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийт:

- Өндөр нас 9274,
- Тахир дутуу-2808,
- Тэжээгчээ алдсан 636,
- Цэргийн тэтгэвэр 617, нийт 13335 тэтгэвэр авагчдад 5103689,52 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

Гурав. Тэтгэмж олголтын талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 153,
- Жирэмсэн амаржсны тэтгэмж 116,
- Оршуулгын тэтгэмж 31 даатгуулагчид нийт 152899,63 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгов.

Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сард нийт 128 даатгуулагчдад 63,3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов.

Тав. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:

Нийт 76 тэтгэвэр авагчдад 35002,16 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

2021 оны 01 дүгээр сарын байдлаар 741385,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагатай байна. Үүнээс 140 аж ахуйн нэгж байгууллагын 548687,1 мянган төгрөг, 43 төсөвт байгууллагын 192698,1 мянган төгрөгийн өр, авлага үүсгэсэн нь Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан заалт биелээгүй байна.

Долоо. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа:

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс 4 удаа хуралдаж, 266 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 18 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 202 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 36 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссийн хурлыг цахимаар зохион байгуулж байна.

2021 оны 01 дүгээр сард нийт 39 иргэний амбулаторийн картыг магадлаж, шинжилгээний бүрдэл дутуу, оношийн үндэслэл хангалтгүй, заалт тохирохгүй шалтгааны улмаас 3 картыг буцаах арга хэмжээ авав.

Түүнчлэн комиссын хурлаар орж буй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үндэслэлд хяналт тавьж, онош заалт тохирохгүй, оношийн үндэслэл хангалтгүй, шинжилгээний бүрдэл дутуу, IQ тодорхойлоогүй зэрэг шалтгааны улмаас 10 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэх арга хэмжээ авлаа.

Ес. Дотоод ажил, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр:

2021 оны 01 дүгээр сард үдийн цайны цагаар 241 иргэнд, 4105 хүнд угтах үйлчилгээг үзүүлсэн. Түүнчлэн нээлттэй утас 70585955 дугаарт хандсан 351 иргэн даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Нийгмийн даатгалын архиваас 33 даатгуулагчид лавлагаа олгохоос гадна бусад 11 аймаг, дүүргийн 22 иргэнд лавлагаа олгож, тэдний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулсан.

Мөн 2006 оноос хойших “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт” програмыг ашиглаж, дахин давтагдашгүй тоон өгөгдөл бүхий QR кодтой лавлагааг 39 иргэнд түргэн шуурхай чирэгдэлгүй олголоо.

Иргэд, даатгуулагчидад нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг цахим хуудас болон орон нутгийн “Мижиг”, “Дорнод” телевизүүдээр хүргэж байна.

Мөн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг цахимд шилжиж байгаатай холбогдуулан 28 иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын аппликэйшнийг баталгаажуулсан байна.

***Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар***

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:

Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:

Тухайн сард 726 ажил хайгч иргэн, үүнээс 372 эмэгтэй бүртгэлтэй байна. Үүнээс 71 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 2,3 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 11.9 хувийг дээд боловсролтой иргэд, 3.1 хувийг суурь боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Цахим хуудсаар ажлын байрны захиалгыг тухай бүр хүргэснээр одоогийн байдлаар 10320 иргэн нэгдэж, мэдээллийн түргэн шуурхай авч байна.

Мөн сард дунджаар 50 орчим мэдээлэл оруулсныг давхардсан тоогоор 13743 орчим иргэн мэдээллийг авч, өмнөх сартай харьцуулахад 49 хувиар өссөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд шинээр санаачилсан ажил, үйлчилгээ:

Зүүн бүсийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлага, мэргэжилтнүүд цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр 2020 онд бусад аймгуудад амжилттай хэрэгжсэн ажлын туршлагаудаас хуваалцаж, 2021 ондоо цар тахалтай холбоотойгоор ажил зуучлалын чиглэлээр хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцов.

Мөн орон нутгийн иргэдийг ажлын байрны талаарх мэдээллээр хангах, улмаар зүүн бүсэд зарлагдсан ажлын байрны зарыг иргэд нэг дороос харах боломжийг бүрдүүлэхээр Зүүн бүсийн “Ажлын байрны нэгдсэн зар мэдээ” фэйсбүүк хуудсыг нээн ажиллуулж, сарын хугацаанд 308 иргэн нэгдсэн байна.

Орон нутгийн “Дорнод” телевиз, “FM-89,1”, “Шуурхай зар” сонин хамтран ажлын байрны зар, ажил хайгч иргэд болон эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн бүтээгдэхүүнүүдийг сурталчлан таниулж байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2019-2020 онд хамрагдсан хувиараа аж ахуй эрхлэгч 41 иргэдтэй утсаар холбогдон мэдээлэл авч, хөтөлбөрт хамрагдсан 7 иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсаар сурталчлан таниулж үйл ажиллагааг нь дэмжсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1676 иргэн хамрагдаж, 509,2 сая, асаргааны тэтгэмжид 1230 иргэн хамрагдаж, 120,7 сая, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 265 иргэн хамрагдаж, 75,2 сая, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж 4715 иргэнд 222,1 сая, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт 12 иргэнд 2,5 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлт 342 иргэнд 19,9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 2252 өрхийн 12600 иргэнд 153,736,000 төгрөгийн 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг олгосон. Үүнээс: Хэрлэн сумын 11 багийн 1762 өрхийн 9882 иргэнд 120,712,000 төгрөг мөн бусад 13 сумын 490 өрхийн 2718 иргэнд 33,024,000 төгрөгийг зарцуулсан.

Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, тулгалтаар мэдээлэл зөрүүтэй гарсан 126 өрх байна. Үүнээс Хэрлэн сумын 55 өрхтэй утсаар холбогдож, холбогдох баримтыг үндэслэн зөрүүг завсарлуулах талаар мэдээлэл өгсөн. Мэдээллийн зөрүүг холбогдох баримтаар завсарлуулсан 15 өрхийн оноог бодуулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлээд байна.

Шинэкоронавируст /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор айл өрхөөр зочлохыг хориглосон тул өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажил хийгдэхгүй байна.

Өрхийн нэгдсэн мэдээллийн санд 2021 оны 1 дүгээр сард 71 өргөдөл, гомдол ирснээс 22 нь судалгаанд хамрагдах, 49 нь хүүхдийн мөнгө болон Иргэний эрүүл мэнд, даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл гаргасан байна.

Судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан 49 иргэний хүсэлтээс бусад хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. Судалгаа нь цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шийдвэрлэх боломжгүй байна.

Тайлант хугацаанд шинээр төрсөн хүүхдүүдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулахаар өрхийн мэдээллийн санд 148 хүүхдийг шинээр бүртгэж, үйлчилгээнд хамрагдаж боломжтой болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 оны хийх ажлын төлөвлөгөө, хурал хийх хуваарь гаргаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, нийт 19 хүүхдийн асуудал хэлэлцэн 4 хүүхдийг байнгын асаргааны тэтгэмжид шинээр оруулж, 14 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 1 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон.

Төрийн бус байгууллагын тэргүүлэгчдээс энэ онд хийх ажлын төлөвлөгөөг авч 2 удаа хуралдан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлын талаар хэлэлцсэн.

Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний тусламж үзүүлэх ажлын хэсэг ажиллаж байна.

Улсын онцгой комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 45 дугаар тушаалаар “Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар, хамгааллын дэглэм мөрдөх түр журам”-ыг баталсан. Түр журмыг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэй

ажлын хэсгийг байгуулж, түр журмын 2 дугаар бүлгийн 2.1 дэх зүйлийн шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн хэмжээнд хүнс, тэжээлийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүн амын зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийг овог нэр, регистрийн дугаар, гэрийн хаяг, утасны дугаар, ам бүл зэрэг 17 үзүүлэлтээр гаргаж тодорхойлсон. Мөн 14 сумын хэмжээнд хүнс, тэжээлийн дэмжлэг хүргэх ажлын хэсгүүдийг байгуулсан. Үүнд: Хэрлэн сумын хэмжээнд 3007 өрхийн 12,446 иргэн, бусад 13 сумын хэмжээнд 666 өрхийн 2,564 иргэн байна. Нийт 3673 өрхийн 14,998 иргэний мэдээллийг нэгтгэн боловсруулсан.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зарласан Магадлан итгэмжлэл авах сонгон шалгаруулалтад магадлан итгэмжлэлээ сунгуулах хүсэлт гаргасан 5 төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, шинээр магадлуулах хүсэлт гаргасан 2 иргэнд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан.

Нээлттэй утас 77661220, 70582255 дугаарт 1 дүгээр сарын байдлаар нийт 929 дуудлага ирснээс Хөдөлмөрийн хэлтсийн 22, Халамжийн хэлтсийн 907 дуудлага ирсэн байна.

Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг **Эрүүл мэндийн газар:**

“Хавдартай тэмцэх” дэлхийн өдрийг энэ жил цахим хэлбэрээр тэмдэглэж, орон нутгийн өнгөрүүлсэн “Нутаг 21”, “Дорнод” телевиз, “Жаран.мн” сайтад хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэлтийн талаарх зөвлөгөө, зөвлөмжийг хүргэж, цахим хуудсанд 4 төрлийн зөвлөмж, шторк байршуулсан бөгөөд 5004 хандалт авч, 500 хүн дэмжиж, 25 хүн хуваалцжээ.

“Маскаа зүүе гараа угаая” аяны хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Хэрлэн сумын “Anna home” асрамжийн газрын 25 хүүхдэд цахимаар сургалт зохион байгуулж, зорилтот бүлгийн өрхийн 17 хүүхдүүдэд “Гарын ариун цэврийн багц”-ыг гэрээр хүргүүлсэн.

Осол гэмтлээс сэргийлэх зорилгоор “Хором бүрээ анхааръя” 1 сарын аяныг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Аяны хүрээнд гэрээт 2 телевизээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн гэмтлийн эмч, Хэрлэн сумын “Ягаанцээнэ” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар зөвлөгөө, зөвлөмжийг хүргэсэн. Дорнод аймгийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвийн цахим хуудсанд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг видео зэргийг байршуулан иргэд, олон нийтэд сурталчилсан

Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

/COVID 19/ халдвараас урьдчилан сэргийлэх ажлын талаар: “Ажлын горимд өөрчлөлт оруулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/564 дүгээр захирамжийн хүрээнд тус байгууллагын ажлын горимыг тусгай горимд шилжүүлэн, цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлтийг заавар зөвлөмжийн дагуу тогтмол хийж ажиллаж байна.

МАЛ АЖ АХУЙ:

Хаваржилтын бэлтгэл ажлын талаар: Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцэст 5650 малчин өрхөд 2,749,027 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 6.1 сая толгой мал хаваржиж байна. Өмнөх онтой харьцуулахад 83344 толгой буюу 4,3 хувиар өссөн дүнтэй байна.

Төллөх малын төлөвлөгөө: Аймгийн хэмжээнд оны эхэнд 1233963 толгой хээлтэгч тоолуулсан, үүнээс 1043356 толгой буюу нийт хээлтэгчийн 85 хувь нь төллөх төлөвлөгөөтэй байна.

Том малын зүй бус хорогдол: 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар том малын зүй бус хорогдлоор 1449 толгой буюу нийт малын 0,05 хувийг эзлэж байна. Үүнээс: Адуу 61 толгой, үхэр 215 толгой, хонь 461 толгой, ямаа 712 толгой мал хорогдсон байна.

Өвс, тэжээл бэлтгэл, зарцуулалтын талаар: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2021 оны өвөлжилт, 2021 оны хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өвс, тэжээлийн бэлтгэсэн байдал хүснэгтээр:

Төрөл	Бэлтгэх		Бэлтгэсэн		Хувь		Дундаж хувь
	Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс	Тэжээл	
Аймгийн аюулгүйн нөөц	700	150	199.7	53.8	24.6	35.8	30.2
Сумын аюулгүйн нөөц	1400	560	1412.6	363.8	100.9	64.9	82.9
Малчдын түвшинд	89928	360	92206	333.8	102.5	92.7	97.6
Нийт	92028	1070	93818.3	751.4	76.0	64.4	70.2

Өвс, тэжээлийн зарцуулалт: 2021 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн байдлаар:

Төрөл	Бэлтгэсэн /тн/		Хувь		Зарцуулсан /тн/		Хувь		Үлдэгдэл /тн/		Хувь	
	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	эжээл	Өвс	Тэжээл
Сумын аюулгүйн нөөц	1412.6	363.8	100.9	64.9	627.4	241.7	44.4	66.4	785.2	122.1	53.6	33.5
Малчдын түвшинд	92206	333.8	102.5	92.7	60849.5	259	66.0	77.6	31356.3	74.8	34.0	22.4

Аймгийн цасан бүрхүүл: Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын эрсдэлийг үнэлэхэд Халхгол сум **Цагаан зудтай**, Матад сумын баруун болон урд хэсгээр **Цагаанаар зудархуу**, бусад сумын нутгаар хэвийн байна.

Аймгийн хэмжээнд Матад, Халхгол сумдын хаваржилт хүндэрсэн нутагт 198 малчин буюу нийт малчин өрхийн 3,5 хувь, 118488 толгой буюу нийт малын 4,3 хувь нь байна. Үүнээс:

Халхгол сум: Халхгол сумын нутаг дэвсгэр 100 хувь цасан бүрхүүлтэй байгаагийн 70-80 хувьд нь цагаан зудтай байна. Үүнд:

- ❖ Цогтсүмбэр 1 дүгээр багийн 90-н баатар, голын ар, Тохой, Цагаан үзүүр, сумын төв
- ❖ Ташгай 3 дугаар багийн Хунт, Баянбүрд, Түвшиндалан, Хавтгай ус, Азарга, Атар-2, Атар-3

Сумын цагаан зудтай цаг хүндэрсэн газарт 145 малчин өрх буюу нийт малчин өрхийн 53,1 хувь, 30338 толгой мал буюу 30,8 хувь нь байна. Үүнд: Адуу 5908 толгой, тэмээ 100 толгой, үхэр 6876 толгой, хонь 8289 толгой, ямаа 9165 толгой байна.

Халхгол сумын хэмжээнд том малын зүй бус хорогдлоор 132 толгой буюу нийт малын 0,13 хувь нь хорогдсон байна.

Үүнд: Адуу 0 толгой буюу хувь, Үхэр 1 толгой буюу 0,005 хувь, Хонь 52 толгой буюу 0,15 хувь, Ямаа 79 толгой буюу 0,29 хувь нь хорогдоод байна.

Халхгол суманд отроор өвөлжиж байгаа малын судалгаа: Халхгол сумын Ялалт багийн Тамсагбулагт Баянхонгор аймгийн Өлзийт сумын 1,2 багийн 7 өрхийн 5310 толгой мал оторлож байна. Үүнд: Тэмээ 0 толгой, Адуу 843 толгой, Үхэр 281 толгой, хонь 1844 толгой, ямаа 2324 толгой, Сарлаг 18 толгой байна.

Цагаан зудтай байгаа газар нутагт отороор ирсэн малчид өвөлжиж хаваржаагүй байна.

Матад сум:

- ❖ Жаргалант 1 дүгээр багийн Баянбүрд, Сүмийн гол, хөх дэрсний говь,
- ❖ Баянхангай 2 дугаар багийн Дулдуйт, Өгөөмрийн говь, Цагаан даравгай, Чонотын хулс, Хашаат улаан өндөр, Баян-өлзий, Цагаан дэрс, Бууртын хошуу, Ухант
- ❖ Буян-Өндөр 4 дүгээр багийн Дулдуйт, Бөмбөгт, Бухын хашаат, Аман ус, Хүрэн толгой,
- ❖ Эрдэнэбадрах 6 дугаар багийн Багана, Тойром, Ногоотын үе, Тосон уул, Гальбирт, Цагаанчулуут, Дунд хөөвөр, Бүрдэнэ гол, Шорвог, Лаг, Их булан гэдэг газруудаар цагаанаар зудархуу байна.

Сумын цагаанаар зудархуу цаг хүндэрсэн газарт 53 малчин өрх буюу нийт малчин өрхийн 11,7 хувь, 88150 толгой мал буюу 42,1 хувь нь байна. Үүнд: Адуу 6060 толгой, үхэр 16860 толгой, хонь 33116 толгой, ямаа 32114 толгой байна.

Матад сумын том малын зүй бус хорогдлоор 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар том малын зүй бус хорогдлоор 1218 толгой буюу нийт малын 0,04 хувийг эзлэж байна. Үүнээс: Адуу 41 толгой, үхэр 199 толгой, хонь 388 толгой, ямаа 590 толгой мал хорогдсон байна.

Матад сумын хэмжээнд том малын зүй бус хорогдлоор 976 толгой буюу нийт хорогдсон малын 80,1 хувь нь хорогдсон байна.

Үүнд: Адуу 23 толгой буюу 56 хувь, Үхэр 173 толгой буюу 86,9 хувь, Хонь 302 толгой буюу 77,8 хувь, Ямаа 478 толгой буюу 81,0 хувь нь хорогдоод байна.

Матад суманд отроор өвөлжиж байгаа малын судалгаа: Аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотын 2 дүүрэг болон 10 аймгийн 22 сумын 103 өрхийн 64069 толгой мал отор нүүдлээр 10 суманд ирээд байна.

Матад суманд Баянхангай, Жаргалант багуудад Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 35 өрх буюу нийт отроор ирсэн малчин өрхийн 33,9 хувь, 34702 толгой мал буюу нийт отороор ирсэн малын 54,1 хувийг эзлэж байна. Үүнд: Тэмээ 223 толгой, Адуу 3002 толгой, Үхэр 2860 толгой, хонь 20209 толгой, ямаа 8408 толгой байна.

Цагаанаар зудархуу байгаа газар нутагт отороор ирсэн малчид өвөлжиж хаваржаагүй байна.

Матад, Халхгол сумдын өвс, тэжээл бэлтгэл, зарцуулалтын талаар:

Сумын нэр	Төрөл	Бэлтгэсэн/тн/		Хувь		Зарцуулсан /тн/		Хувь		Үлдэгдэл /тн/		Хувь	
		Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл
Матад	Сумын аюулгүйн нөөц	100	26.3	100	65.7	85	24.8	85	94.2	15	1.5	15	5.7
	Малчдын түвшинд	5335	21.3	69.8	85.2	5335	16.3	100	76.5	0	5	0	24.3
Халхгол	Сумын аюулгүйн нөөц	100	38	100	95	14	7	14	18.4	86	31	86	81.5
	Малчдын түвшинд	3390	18	82	20	2940	16.4	86.7	91.1	450	1.6	13.2	8.8

Улсын аварга болон хошой аварга малчин өрх шалгарлаа: Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит хуралдаанаас:

“Улсын аварга малчин өрх”-өөр: Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Хүрээт багийн малчин Дамдины Пүрэв, Чойбалсан сумын Сүмбэр багийн малчин

Шамбийгийн Намхай, Чулуунхороот сумын Галуут багийн малчин Пүрэвдоржийн Дамдинлхагва, Матад сумын Жаргалант багийн малчин Дуламжавын Цогтбаяр, Цагаан-Овоо сумын Элст багийн малчин Чогсомын Баатархүү.

“Улсын хошой аварга малчин өрх”-өөр: Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Батхаан багийн малчин Шагдарын Шаравжамц нар тус тус шалгарсан.

Аймгийн аварга малчин өрх шалгарлаа: Аймгийн Засаг даргын 2021 оны А/83 дугаар захирамжаар “Аймгийн аварга малчин өрх” цол тэмдэгээр 14 сумын 26 малчин өрх шалгарлаа.

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Мал үржлийн албаны дарга, мэргэжилтэнүүдтэй цахим уулзалт, хэлэлцүүлэг хийлээ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хэрэгжүүлэх зохицуулах газраас зохион байгуулж буй Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, мал төллөлт, төл хүлээн авах үеийн бэлтгэл хангах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг улсын хэмжээнд боловсруулж байгаатай холбогдуулан санал авах талаар 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдөр цахим уулзалт, хэлэлцүүлэгт аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Мал үржлийн албаны дарга, мэргэжилтнүүд нийт 126 албан хаагчид хамрагдлаа.

Уулзалт, хэлэлцүүлгийн үеэр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хэрэгжүүлэх зохицуулах газрын дарга Д.Батмөнх улсын хэмжээний хаваржилт, аймгууд Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар хаваржилтын талаар мэдээллээ танилцуулж, аймгуудын санал хүсэлтийг сонсож, үүрэг чиглэл өгч ажиллаа.

Уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хаваржилтын талаар төлөвлөгөөнд оруулах 5 санал хүргүүлж ажиллаа. **Үүнд:**

1. Отороор ирсэн малчин өрхийг тухайн аймаг нь 04 дүгээр сарын 01-ний дотор татан авах ажиллагааг зохион байгуулж, малчин өрхүүдэд аймгууд анхаарал хандуулах
2. Мал аж ахуйн хаваржилтын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, мал төллөлт, төл хүлээн авах үеийн бэлтгэл хангах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 8-д заасан хугацааг 3-6 сар болгон өөрчлөх саналтай байна.
3. Мөн үзлэг ангилалтын санхүүжилтыг цаг хугацаанд нь олговол, үзлэг ангилалтыг технологит хугацаанд хийхэд бэлэн байна.
4. Ноолуур дээр төр хэрхэн хамтран ажиллах вэ? Ноолуурын бэлтгэл үед улсын нэгдсэн аян зохион байгуулвал ямар вэ?
5. Манай аймгийн хувьд Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед өөрийн аймгийн сум хооронд ноолуур бэлтгэл, тээвэрлэх ажлыг 3 дугаар сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулахаар

удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулахаар төлөвлөж байна.

Дорнод аймагт ноолуур худалдан авдаг төлөөлөгчидтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа: Монгол улсад коронавирус /COVID-19/ цар тахал бүртгэгдсэнтэй холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед өөрийн аймгийн сумд хооронд ноолуур зах зээлд борлуулах болон худалдан авах, тээвэрлэлтийг зохицуулах зорилгоор Дорнод аймагт ноолуур худалдан авдаг төлөөлөгчидтэй 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Хэрлэн сумын ЗДТГазрын хурлын танхимд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уулзалт, хэлэлцүүлэгт Хэрлэн сумын Засаг дарга, орлогч, Хэрлэн сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнгүүд, аймгийн ХХААГазрын 2 мэргэжилтэн, ноолуур худалдан авдаг төлөөлөгч 8, нийт 16 хүн оролцсон.

Уулзалт, хэлэлцүүлгийн үеэр Ноолуур худалдан авдаг төлөөлөгч нарт Улаанбаатар хотоос ноолуур авахаар ирэх төлөөлөгчдийн хөдөлгөөнийг халдвар хамгаалалтын дэглэм барьж ажиллуулах, мөн 03 дугаар сарын 01-ний дотор Улаанбаатар хотоос ирэх төлөөлөгчдийн мэдээллийг авч нэгтгэн аймгийн онцгой комиссын шуурхай штабд танилцуулах мөн аймгийн арван найман төлөөлөгч ноолуур авах газар байршилаа ойрын хугацаанд тогтож мэдээллэх, ноолуурын үнэ ханшийг Улаанбаатар хотын үнэ ханшнаас буулгахгүй байх, хотоос ирэх төлөөлөгчдийг нэгдсэн журамаар авчирч, тусгаарлах байранд байршуулан 14 хоногийн дараа хариуцсан төлөөлөгчдөд хүлээлгэн өгөх, өөрийн аймгийн сумд хооронд ноолуур зах зээлд борлуулах болон худалдан авах, тээвэрлэлтийг зохицуулах талаар чиглэл өгч, санал бодлыг нь сонсож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Ноолуур худалдан авдаг төлөөлөгч нарын өгсөн байршлын дагуу газар дээр нь очиж уулзаж чиглэл өгч ажиллаа: Аймгийн шүр захад байрлалтай ноолуур худалдан авах цэгт 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 4 төлөөлөгчидтэй уулзаж ноолуур худалдан авч, тээвэрлэх тухай аймгийн түр журам батлуулж хэрхэн ажиллах талаар чиглэл өгч хэрвээ түр журмыг зөрчсөн ноолуур бэлтгэн нийлүүлэгч, борлуулагч малчин, мал бүхий иргэн, ноолуур худалдан авч, тээвэрлэх төлөөлөгч, иргэн, аж ахуйн нэгжийг Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох талаар мэдээлэл өгч ажиллаа.

“Бог малын үржлийн ажлыг зорилтот бодлогын хүрээнд явуулах, ноолуурын чанарын үзүүлэлт тодорхойлох” чиглэлээр цахим сургалт зохион байгууллаа: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол “Ноолуур” хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн мал аж ахуйн

салбарыг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Бог малын үржлийн ажлыг зорилтот бодлогын хүрээнд явуулах, ноолуурын чанарын үзүүлэлт тодорхойлох” цахим сургалтыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтын нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Алимаа, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн “Ноолуур судлал”-ын лабораторийн эрхлэгч, доктор Б.Нарантуяа, доктор Ц.Цэеэнханд, “Тогтвортой ноос ноолуурын эвсэл”-ийн Монгол дахь салбарын захирал, доктор Б.Батхишиг, Дорнод аймаг дахь Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Алтансүх нар оролцож, мэдээлэл өгч, санал, бодлыг сонсож, үүрэг чиглэл өгч ажиллаа.

Шалгуур үзүүлэлт	Нийт эргэлтийн талбай (га-аар)	2021 оны зорилт												Бэлтгэх уринш га-гаар		
		Нийт эргэлтэнд орох талбай га-гаар	Тариалах талбай га-гаар													
			Нийт тариалах талбай га-гаар	Үр тариа	Үүнээс						Малын тэжээл	Тосны ургамал	Төмс		Хүнсний ногоо	Жимс
					Буудай	Арвай	Овьёос	гурвалжин будаа	Бусад							
1 Тариалах талбай (га-аар)	95034	55991	31891	23870	21540	70	960	1500	1300	5500	2100	189	127	105	24100	
2 Хураан авах ургац (тн-оор)				29690	26925	70	1200	900	1495	11000	1470	2419	1500	13		
3 Га-ийн дундаж ургац (цн-ээр)				12.4	12.5	10.0	12.5	6.0	11.5	20.0	7.0	128.0	118.1	1.3		

Цахим сургалтанд 14 сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, багийн засаг дарга нар, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, сумдын Хөдөө аж ахуйн хоршооны дарга нийт 134 хүн оролцсон. Сургалтын үеэр Бог малын үржлийн ажлыг зорилтот бодлогын хүрээнд явуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Ямааны ашиг шимийг нэмэгдүүлэх үржлийн ажлын стратеги төлөвлөлт, малчдын нөхөрлөл, хоршоо, багт үржлийн ажлыг зохион байгуулах болон мэргэжилтний оролцоо, хяналт, Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн үр ашигтай эрхлэх, удирдан зохион байгуулах технологи ажил нь Мал зүйч мэргэжилтэний чиг үүрэг, Ноолуурын худалдааны олон улсын шаардлага ба малчдын оролцоо, Цагаан-Овоо суманд өсгөн үржүүлж буй “Нутгийн хар ямааны судалгааны ажлын үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллүүдийг тавьж, санал бодлыг нь сонсож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Энэхүү цахим сургалтыг зохион байгуулснаар цаашид сумдын ноолуурын дээж авч тодорхойлох, ноолуурын чанарыг баталгаажуулж нөөц боломжийг тодорхойлох ажил хийгдэх юм.

Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малд үзлэг ангилалтын чиглэлээр цахим сургалт зохион байгууллаа: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Генетик нөөцийн хэлтэсээс зохион байгуулсан Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малд үзлэг ангилалтын чиглэлээр цаг үетэй холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр цахим уузалт, хэлэлцүүлэгт 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга, мэргэжилэн нийт 105 албан хаагч хамрагдсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Генетик нөөцийн хэлтсийн дарга Д.Батсүрэн Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малд үзлэг ангилалтын чиглэлээр мэдээлэл өгч, санал хүсэлтийг сонсож, хариулт өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үүрэг чиглэл өглөө.

ГАЗАР ТАРИАЛАН:

Төлөвлөлт: Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮЯамны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээгээр 23,8 мянган.га-д үр тариа, үүнээс 21,5 мянган.га-д улаан буудай, 2,1 мянган.га-д тосны ургамал, 5,5 мянган.гад малын тэжээл 189 га-д төмс, 127 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 29,6 мянган.тн, үүнээс 26,9 мянган .тн улаан буудай, 3,8 мянган тн бусад үр тариа, 1,4 мянган.тн тосны ургамал, 2,4 мянган.тн төмс, 1,5 мянган.тн хүнсний ногооны ургац хураан авахаар төлөвлөөд байна.

Тэргүүний тариаланч, тариаланч хамт олныг шалгаруулав: XVII жарны “Цагаагчин Үхэр жилийн хаврын тэргүүн сарын Шинийн нэгэн Монголын цагаан сарын баярыг тохиолдуулан Газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж ирсэн тэргүүний тариалан, тариаланч хамт олныг шалгаруулав.

Үүнд: “Аймгийн аварга тариаланч хамт олон”-оор “Майдарын буудай” ХХК, “Аймгийн аварга тариаланч” цол, тэмдгээр Баяндун сумын 4 дүгээр багийн тариаланч Төмөрийн Амгалан, Баянтүмэн сумын 1 дүгээр багийн тариаланч Баатарын Батболд, Хэрлэн сумын 2 дугаар багийн тариаланч Сүхбаатарын Энхтулга нар шалгарсан.

Талбай эзэмшигчдын судалгаа: Аймгийн хэмжээнд төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар талбай эзэмшигчдын судалгааг 2021 оны 02 сарын 03 өдрийн 76, Үр тариа, тэжээлийн ургамал тариалах талбай эзэмшигчдын судалгааг 2021 оны 02 арын 19 өдрийн 83 тоотын дагуу татан авч нэтгэн аймгийн ХОХБТ хэлтэст хүргүүлэн ажиллав.

Үүнд: төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар Хэрлэн, Баяндун, Цагаан-Овоо, Дашбалбар, Баян-Уул, Халхгол, Булган, Хөлөнбуйр, Чулуунхороот, Чойбалсан

сумдад, 26 аж ахуйн нэгж, 330 иргэн 530,7 га талбай эзэмшиж байгаа бөгөөд үүнийн 30,3 нь ашиглагдаж байна.

Үр тариа, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 12 суманд 36 аж ахуйн нэгж 7 иргэн нийт 95034 га эзэмшиж байгаа бөгөөд үүнээс энэ онд урьдчилсан байдлаар 40175 га-д тариалж, 32084 га уриншийн боловсруулалт хийх талаар захиалгаа ирүүлээд байна. Судалгааг үндэслэн тариалалтыг нэмэгдүүлж хүн амын хүнсний хэрэгцээ хангамжийг бүрдүүлэх боломж байна.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сум хөгжүүлэх сан: Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019, 2020 онуудад олгосон зээл, зээлийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж ажиллахад:

1. 2019 онд аймгийн хэмжээнд 162 иргэн, аж ахуйн нэгжид 1146.7 сая төгрөгийн зээл олгож 230 ажлын байрыг бий болгосон. Зээлийн дундаж хэрэгжилт 60 хувьтай, зээлийн эргэн төлөлт хэвийн зээлдэгч 93, хэвийн бус зээлдэгч 69 байна.
2. 2020 онд аймгийн хэмжээнд 88 иргэн, аж ахуйн нэгжид 505.9 сая төгрөгийн зээл олгож 128 ажлын байрыг бий болгосон. Зээлийн дундаж хэрэгжилт 56 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2019, 2020 онуудад нийт 248 зээлдэгчид 1643.5 төгрөгийн зээлийг олгож, нийт 358 ажлын байрыг хадгалан үлдсэн байна. Нийт зээлийн хэрэгжилт болон эргэн төлөлт аймгийн хэмжээнд 60 хувь, сум хөгжүүлэх сангийн хяналтын программын ашиглалт дундажаар 76 хувь байна.

2020 оны зээлийн хэрэгжилтийн талаарх санал дүгнэлт, зөвлөмжийг сум бүрт гарган, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тоотоор хүргүүлэн ажилласан.

Зээлийн батлан даалт: Зээлийн батлан даалтын сангийн бүтээгдэхүүн үйлчилгээ, батлан даалтын талаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдад мэдээлэл өгч, холбогдох асуултад зөвлөгөө өгч ажилласан.

Жижиг, дунд үйлдвэр: Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлэх хүсэлтэй 2 аж ахуйн нэгжийг материалыг хүлээн авч, жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн шаардлагыг хангасан тул тодорхойлолт олгосон.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 онд арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлд хяналт, үнэлгээ хийх зорилгоор 02 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд “Үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх” удирдамжийн дагуу “Нутгийн тус” ХХК, “Давст оргил” ЗГБНХ, “ОРУМ” ХХК, “Энх Мөнх Божу” ХХК, Д.Батболд, “Эрдэнэбилгүүдэй” ХХК, “БАБУБ” ХХК, “Сэмбо” БГБХН, Д.Оюунбаатар,

Э.Эрдэнэбулган, “Авто агро” ХХК зэрэг 12 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, зээлийн хэрэгжүүлэлт, эргэн төлөлт, үр дүнг тооцож ажилласан.

Хамрагдсан 11 иргэн аж ахуйн нэгжид үнэлгээ хийхэд 33 хувь нь төслийн зориулалтын дагуу ашиглаагүй, 66 хувь нь төслийг үр дүнтэй зориулалтын дагуу зарцуул, тодорхой хэмжээгээр ажлын байр нэмэгдүүлж, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулсан байна.

Коронавируст халдвар /ковид-19/ гарсантай холбоотойгоор түүхий эдийн үнэ нэмэгдсэн, Хятад улсаас оруулж ирэх тоног төхөөрөмж гацсан байдалтай, худалдан авах чадвар 30 хувь буурсан, тээвэрлэлт хязгаарлагдсан гэх мэт асуудлууд гарч байгааг ажилчдын тоог бууруулж, цомхотгол хийсэн газар байхгүй байна.

Тайлан хүргүүлсэн тухай: Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан 21:100 хөтөлбөрийн тайланг ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн газарт хүргүүлсэн. Мөн арьс, шир түүхий эдийн үнэ ханшийн мэдээг 7 хоног бүрийн пүрэв гараг бүр хүргүүлэн ажиллаж байна.

ХҮНС, ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Уулзалт зохион байгуулсан тухай: Аймгийн Засаг даргын санаачлагаар коронавируст халдвар /ковид-19/ цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр аймгийн томоохон худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжийн захирал, ачаа тээврийн жолооч нартай уулзалт зохион байгуулж, Улаанбаатар хотоос Дорнод аймагруу болон Дорнод аймгаас Улаанбаатар хотруу ачаа тээвэрлэлтийн явцад үүсэж буй хүндрэл бэршээлийн талаар гарсан санал хүсэлтүүдийг авч ажилласан.

Уулзалтын үр дүнд 10 аж ахуйн нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллав.

Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, үнийн мэдээ: Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хэрлэн сумын 11 багийн 34 хүнсний дэлгүүрээс гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн судалгаа авч, 11 дүгээр сарын үнийн судалгаатай харьцуулалт хийж аймгийн онцгой комисст танилцуулж ажиллалаа. Мөн аймгийн Засаг даргын А/565 дугаар захирамж “Зарим төрлийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” түр журмын хэрэгжилттэй танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээ болон гамшгийн үеийн 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний судалгааг 14 сумаас авч орон нутгийн хүн амын тоонд харьцуулан гаргаж 7 хоног бүрийн даваа, пүрэв гарагт ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.

Дотоодын хүнс үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт зохион байгуулсан тухай: Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг болон худалдаалдаг иргэдээс гарсан санал, санаачлага, аймгийн Онцгой комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2021 ны 02 дугаар сарын 03-ны өдөр Хэрлэн сумын дотоодын хүнс үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зохион байгуулсан сургалтад сургалт мэргэжилтэн П.Даваасүрэн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуультай холбогдон гарсан шийдвэрүүд” сэдвийн хүрээнд сургалт, мэдээлэл хийв.

Сургалтанд Хэрлэн сумын Засаг дарга О.Пүрэв-очир, Хөдөө аж ахуйн тасгийн дарга Ж.Гэрэлмаа, аймгийн Орон нутгийн өмчит худалдан авах ажиллагааны газрын дарга М.Нямсүрэн, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Д.Уянга, аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн П.Даваасүрэн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг болон сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл нийт 23 хүний бүрэлдэхүүн хамрагдлаа.

Сургалтын үр дүнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналууд гарлаа.
Үүнд:

1. Засаг даргын захирамжаар мэргэжлийн туслан, зөвлөх комисс батлуулж ЕБС-уудын Үнэлгээний хороодод хяналт тавьж ажиллах
2. Сонгон шалгаруулалт хийхээс өмнө тухайн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг нь тухайн үйлдвэрлэл эрхлэгчдийн талбай, ажлын байрыг үзэж тогтоосон байх /Жнь: өөрөө ногоо тариалдаггүй гарал үүсэл нь тодорхойгүй улаанбаатар хотоос хүнсний ногоо тээвэрлэж авчраад нийлүүлдэг/
3. Салбарын мэргэжилтэнгүүдийг /АЗ/ сертификатын сургалтад хамруулж үнэлгээний хороонд оруулах болон зөвлөн туслах ажлыг тухайн сургууль, цэцэрлэг дээр байгуулагдсан үнэлгээний хороодод хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх зэрэг санал хүсэлт гарсан болно.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

ХХААЯам, орон нутаг, холбогдох байгууллагаас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд давхардсан тоогоор 19 албан хаагч, цахим хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 10 албан хаагч, ажлын байран дээрх 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 53 албан хаагчийг тус тус хамруулж, хариуцсан ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэн ажиллаж байна.

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Мал эмнэлгийн газар нь 2021 оныг “Хамтын ажиллагаа-Цахим шинэчлэл” гэсэн зорилтот жилийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

"Монгол мал үндэсний хөтөлбөр", Малын бруцеллёзтой тэмцэх стратеги төлөвлөгөөг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, хээлтүүлэгч, хээлтэгч малын бруцеллёз өвчний халдварлалт, тархалтыг тогтоох, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны №04 тоот удирдамжаар 3 дугаар сарын 01-ээс, 6 дугаар сарын 01-ний хооронд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Хэрлэн, Чойбалсан сумдын ЗДТГ, МЭТ, МЭҮН-тэй хамтран 10,000 толгой хээлтүүлэгч, хээлтэгч малаас цус, сүүний дээж цуглуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Мал эмнэлгийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалт:

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Мал эмнэлгийн газрын даргын батласан 2021 оны 40-01-386/02 удирдамжаар томилогдсон ажлын хэсэг Хэрлэн сумын нутаг дэвсгэрт малын эмийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг /“Дорнын цагаан дэрс” ХХК, “Хангал хулан” ХХК, “АЖХ” ХХК, “Түмэн сувд сүрэг” ХХК, “Их дэлгэрэх буянт” ХХК, “Ашигт Фийд” ХХК, “Дорнын унага” ХХК / 7 аж ахуй нэгжүүдэд хяналт, шалгалт явуулж ажиллалаа.

Хяналт шалгалтаар аймгийн хэмжээнд сүүлийн үед зонхилон тохиолдож буй шимэгчтэх, халдваргүй өвчний үед хэрэглэгдэх эм бэлдмэлийн нөөцийг тогтоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мал эмнэлгийн үйл ажиллагааны сургалт, зөвлөгөөний талаар:

Удирдлагын академиас зохион байгуулсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаарх сургалтанд МЭГ-ын 2 мэргэжилтэн хамрагдсан.

Мал эмнэлгийн газраас “ХАМТЫН АЖИЛЛАГАА-ЦАХИМ ШИНЭЧЛЭЛ-2021” зорилтот жилийн хүрээнд сумдын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, ажлын үзүүлэлтээрээ бусдыгаа манлайлж ажилласан тасаг, албан хаагчдыг урамшуулж салбарын шагнал гардууллаа.

Сургалтаар Мал эмнэлгийн салбарын хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тогтоол шийдвэрүүд, орон нутгийн түвшинд тулгамдаж буй асуудлууд, малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл, мал эмнэлгийн ажил үйлчилгээ, малын эмийн зохистой хэрэглээг хангуулах, мах худалдан борлуулдаг зах, үйлдвэрүүдэд QR код нэвтрүүлэх талаар мэдээлэл өгч, мөрдөн мөшгих тогтолцоо, мал эмнэлгийн цахим системийн багаж төхөөрөмжийг хүлээлгэн өгөх, ашиглалтын гэрээ, 2021 оны Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гуравласан гэрээг байгуулах, тасгийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулан ажилласан.

Мал эмнэлгийн хөрөнгө оруулалт:

Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөрдөн мөшгих тогтолцоо, мал эмнэлгийн цахим гэрчилгээг нэвтрүүлэхээр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 139,2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төрлийн багаж төхөөрөмжийг аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатаар ахлуулсан ажлын хэсэг Мал эмнэлгийн газарт хүлээлгэн өглөө.

Дорнод аймаг мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөрдөн мөшгих тогтолцоо, мал эмнэлгийн цахим нэгдсэн системийг орон нутгийн хөрөнгөөр 100% шийдвэрлэж байгаагаараа улсын хэмжээнд онцлогтой юм.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Зорилтод жилийн хүрээнд тус байгууллагаас салбарын бодлого шийдвэрийг танилцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 4 удаагийн цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан давхардсан тоогоор 197 иргэн, аж ахуйн нэгж, албан хаагчдыг хамруулан ажилласан.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АСУУДЛЫН ХҮРЭЭНД:

Гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх хүсэлт ирүүлсэн 23 иргэдийн гэрээ, хэлцлийг хянан үзэж 7 иргэнд газар өмчлөх эрхийг шилжүүлэн баталгаажуулах захирамж гаргасан.

Аймгийн Засаг даргын захирамжаар иргэний өмчлөлийн газрын хэмжээг өөрчлөх 1, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 4, иргэний газар эзэмших эрхийг дуусгавар болгох 1, Төрийн байгууллагад газар эзэмшүүлэх 1 асуудлыг тус тус шийдвэрлэсэн байна.

Сумдын 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байршлуудаас Баянтүмэн суманд 8 байршлын 10.12 га газарт дуудлага худалдаа зохион байгуулагдаж, үүнээс 4 байршилд оролцогч бүртгүүлж 45.4 сая төгрөгийн дуудлага худалдаа зохион байгуулагдсан байна.

Баян-Уул суманд 15 байршлын 1471.5 га газарт дуудлага худалдаа зарлагдсанаас 15 оролцогч 1.13 тэрбум төгрөгөөр ялагч болсон бол одоогоор 8 ялагч 631,0 сая төгрөгийн төлбөрийг төлж газар эзэмших эрх үүссэн байна.

Бусад 6 байршилд ялагчаар тодорсон иргэн, хуулийн этгээд нь гэрээнд заасан хугацаанд газрын төлбөр төлөөгүй тул эдгээр дахин дуудлага худалдаа зарлагдахаар болсон.

Дашбалбар суманд 1 байршлын дуудлага худалдаа зохион байгуулагдаж 1.08 сая төгрөгөөр 1 ялагч тодорсон бол Хөлөнбуйр суманд 1 байршилд зарлагдсан боловч ганц оролцогчтой учир зохион байгуулагдаагүй байна.

Газрын кадастрын мэдээллийн санд 1871 иргэн аж ахуй нэгжийн кадастрын зургийг оруулж өөрчлөлт хийж, дундын мэдээллийн сангаар дамжуулж 4 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгон, газар эзэмших гэрээ байгуулсан байна.

Газрын кадастрын цахим системд газрын төлбөрийн 2021 оны ногдуулалт үүсгэн татварын удирдлагын цахим системд илгээх ажлыг зохион байгуулж, газрын төлбөрийн нэхэмжлэх 80 хувьтай илгээгдээд байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хэрлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ус-Орчин” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Прокурорын газрын албан конторын барилга”-ын барилга угсралтын ажлыг аймгийн Засаг даргын 2021 А/35 дугаар захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийснээр үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Гурванзагал сумын нутаг дэвсгэрт “Ганханлиг констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Хаан банк”-ны тооцооны төвийн барилгын барилга угсралтын ажилд техникийн хяналт хийж, аймгийн Засаг даргын 2020 оны А/591 дүгээр захирамжаар байгуулагдсан комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан.

Барилга хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас орон зайн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн цахим хуудсууд шинээр нэвтрүүлээд байна.

2019 оноос тус мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн эхлэн одоогоор Хэрлэн сумын нийгмийн дэд бүтэц бүтцийн болон орон сууцны 306 барилгын мэдээллийг оруулаад байгаа бол энэ онд аймгийн хэмжээн дэх бүх барилга болон

авто зам, явган зам, инженерийн шугам сүлжээ, хөшөө дурсгалын мэдээллийг оруулахаар ажиллаж байна.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

“ДААББ” ХХК-ийн гаргасан хүсэлтийн дагуу худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зориулалтыг орон сууцны зориулалттай болгох хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалтын орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн авто зогсоолыг байрны орцны эсрэг талд төлөвлүүлэн зориулалт өөрчлөн загвар зургийг батлахаар шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын үүрэг болгосны дагуу “Дорнод-НАА” ОНӨААТҮГ-ын эзэмшилд байдаг агуулахын зориулалттай 1988 онд ашиглалтад орсон угсармал суурь, тоосгон хана, төмөр бетон дам нуруу, хар цаасан дээвэр бүхий тэнхлэгээр 12,0м x 30,0м хэмжээтэй, хойд талдаа 60м² цутгамал бетон талбайтай барилгын талаарх судалгааг гаргаж улсын байцаагчийн дүгнэлтийн хамт хүргүүлсэн.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа Ш.Ганбат, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Мягмарсүрэн, Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Бямбажав, Халхгол сумын Ялалт багийн Засаг дарга Л.Үржиндорж, Халхгол суман дахь Гал түймэр унтраах, аврах 62 дугаар ангийн захирагч, дэд хурандаа М.Сүхсайхан, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, дэслэгч Д.Батдорж, Байгаль хамгаалагч Э.Хонгорзул, Буйрын усны харуул Ц.Мөнхдалай нарын бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Буйр нууранд осолдсон 2 тээврийн хэрэгслийн унасан газарт очиж ажиллалаа.

Ослын цэг, нуурын толиод үзлэг хийхэд мөсөн дээр түлш, бензин тос тосолгооны бүтээгдэхүүн асгараагүй, нуурын экосистемд ямар нэгэн сөргөөр нөлөөлөх бохирдол үүсээгүй байна.

Халхгол сумын Ялалт баг, Баянхошуу боомтод оршин суух иргэн Б.Ганболд нь Тоёота Платц маркийн 9247 Дор улсын дугаартай тээврийн хэрэгслээр Баянхошуу хилийн заставд ажилладаг Эрдэнэбаатар болон түүний 4 нас, 6 настай 2 хүүхдийн хамт 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 15 цагийн орчимд шашны зан үйл хийх зорилгоор Буйр нуур дээр зорчин явж байх үед мөс цөмөрч, машинаасаа бууж, тээврийн хэрэгсэл осолдсон байна. Тээврийн хэрэгслийн шатахууны банканд 10 литр бензин байсан гэх бөгөөд банкны битүүмжлэл хэвийн байх тохиолдолд нуурын усанд шатахуун алдагдах боломжгүй гэж дүгнэж байна.

Тоёота Плац маркийн 9247 Дор улсын дугаартай тээврийн хэрэгсэл унасан газарт цооног тавьж, хэмжихэд мөсний зузаан 33 см, усны гүн 7 метр байв.

Халхгол сумын Ялалт баг, Буйр цехэд оршин суух иргэн Н.Үүрцайхын “Дорнын Мөнгөн Буйр” ХХК-нь 2021 онд 7,5 тн загас агнах зөвшөөрөл авч, загас агнуур явуулж байгаа бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр нуур дээр Либеро маркийн

тээврийн хэрэгслээр зорчин явж байхад цасан шуурга шуурч үзэгдэх орчин хязгаарлагдаж, зүг чигийн баримжаа алдан төөрч, нуурын мөсний ангалд орж, мөс цөмөрч, машинаасаа буухад машин цөмөрч осолдсон байна.

Тус тээврийн хэрэгслийн шатахууны банк хуванцар байдаг бөгөөд банкны битүүмжлэл хэвийн байх тохиолдолд нуурын усанд шатахуун алдагдах боломжгүй гэж дүгнэж байна.

Иргэн Н.Үүрцайхын Хюндай Либеро маркийн дунд оврын ачааны зориулалтын тээврийн хэрэгсэл унасан газар нь Тоёота Плац маркийн тээврийн хэрэгслээс урд зүгт 12м зайд байх бөгөөд цооног гаргаж хэмжихэд мөсний зузаан 45см /5 хоногийн өмнө хэмжихэд 35см байсан гэх/, усны гүн 7метр, урд зүгт 25м зайд цооног тавьж хэмжихэд мөсний зузаан 63см байв.

Тус тээврийн хэрэгслүүд унасан ослын цэгээс улсын хил 10,9 км, хилийн застав 3,4 км, Буйр загачны тосгон 3,8 км, Халхголын цутгалан 347 метр зайтай, 40 метр орчим зайд харзны ус харагдаж байсан.

Иргэн Б.Ганболдтой уулзаж, тээврийн хэрэгслийг гаргахад шаардагдах зардал /Шатах тослох материал, алба хаагчдын хоол хүнс/-ыг шийдэж, зөвшөөрөх эсэхийг асуухад бүрэн зөвшөөрч байна машинаа гаргуулж авахад шаардагдах зардлыг гаргана гэсэн хариулт өгсөн.

Мөн иргэн Н.Үүрцайхтай холбогдож, тээврийн хэрэгслийг гаргахад шаардагдах Эрэн хайх, аврах ангийн аврах бүлэг аймгаас очих, ирэх, Гал түймэр унтраах, аврах 62 дугаар ангийн бүлгийн Халхгол сумаас ирэх, буцах зардал /Шатах тослох материал, алба хаагчдын хоол хүнс/-ыг шийдэхийг зөвшөөрөх эсэхийг асуухад шаардагдах зардлыг бүрэн гаргана гэсэн хариулт өгсөн.

САНАЛ.

Хюндай Либеро маркийн дунд оврын ачааны зориулалтын тээврийн хэрэгсэл унасан цэгээс урд зүгт 25 метрээс гадагш зайд цооног тавьж, ослын цэгтэй коридороор холбон тээврийн хэрэгслийг дээш татах зориулалт бүхий өргөгч байрлуулж, ОБГ-ын алба хаагч гүний шумбалтын журмыг баримталж шумбалт хийн тээврийн хэрэгслүүдийг оосорлон өргөж чөлөөтэй гаргахад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж зохион байгуулах.

ХОЁР МЭЛХИЙТ НУУРАНД ДЭЭР ХАЛЬТАРЧ ГАРАХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН ЗЭЭРИЙГ ГАРГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ИЛТГЭХ ХУУДАС.

Баянтүмэн сумын эрхлэгч их эмч У.Уртнасангын өгсөн мэдээллийн дагуу 2021 оны 02 сарын 02-ны өдөр Баянтүмэн 2-р баг Булан цагааны нуур гэдэг газарт цагаан зээр мөсөн дээр хальтирч нуурын мөсөн дээрээс гарч чадахгүй байна гэсэн мэдээллийн дагуу очиж ажиллан 120 орчим зээрийг мөснөөс гаргах ажлыг 2 Багийн дарга Д.Буянхишиг, Багийн эмч Х.Батмөнх, Багийн иргэн Д.Галтогтох, Байгаль хагаалагч О.Ганболд, М.Алтанцэцэг нарын хамт зохион байгуулж ажилласан.

Аймгийн байгаль орчны статистик 2020 оны тайланг 14 сумаас холбогдох маягтуудаар цуглуулан 2 дугаар сарын 15-ний өдрийн дотор 84 маягтаар шивж оруулан яамны холбогдох мэргэжилтнүүдээр хянуулж байна. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны www.eic.mn сайтад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу

гаргасан байгаль орчинд нөлөөлөх байдлын 9 дүгнэлтийг шивж мэдээллийн санг баяжууллаа.

Аймгийн эвдэрсэн газрын судалгааг гарган Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүллээ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Байгаль орчны бодлогын хорооны анхдугаар хуралдаанд Орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодис, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн С.Урантогос, ахлах мэргэжилтэн Ц.Нансалмаа нар оролцож “Чойбалсан хотын хог хаягдлын төлөвлөлт, цаашид хийгдэх ажлын талаар мэдээлэл бэлтгэн, хог хаягдлын менежментийг сайжруулахад тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замуудын талаар танилцууллаа.

Тосон-Хулстайн БНГ-т Байгаль орчны багц хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж хэрэгжилтийг хянан шалгах, зөрчлийн шинжтэй мэдээ, мэдээлэл цуглуулах, хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зорилгоор ажиллаа. Уг хяналт шалгалтын ажлаар зөрчил илэрсэнгүй. Мөн тус ажлын хүрээнд зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн, тархац нутгийг тогтоох хээрийн судалгаа, хяналт шалгалтыг бие дааж хийж гүйцэтгэсэн ба судалгаагаар цагаан зээр 40-н шороо хөх хошуугаар 50-60 цагаан зээр цөөн тоогоор өвөлжиж байна.

Баянтүмэн сумын 4-р багийн малчин Ц.Отгонбаатарын хашаанд тэжээж байгаа аргал хонь /хом/-д биотехникийн арга хэмжээний зардлаас өвч тэжээл, будаа өгч өвөлжилтийн байдалтай танилцлаа. Анх ирсэн үетэй харьцуулахад тарга тэвээргэ сайн авсан байна.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, газрын дарга А.Гантулга нар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар “Аргачлал, загвар батлах тухай” тушаалын дагуу баталгаажуулсан юм.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хэлтсийн дэргэдэх Орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн 2 дугаар хурлаар дараах газруудад тохирлын гэрчилгээ олгосон

Үйлчилгээ		
д/д	Нэр төрөл	2 дугаар хурал
1	Хүнсний дэлгүүр	4
2	Хүнсний мухлаг	3
3	Ресторан	2
4	Зочид буудал	2
5	Дэн буудал	1
6	саун	1
7	Нийт	13

- Экспортын бүтээгдэхүүн баталгаажуулалт

Д/д	Нэр төрөл	Тохирлын гэрчилгээний тоо	Хэмжээ /тонн/	Аж ахуйн нэгж
1	Хар тугалганы баяжмал	22	2240	“Шинь шинь” ХХК
2	Цайрын баяжмал	53	5184	
3	Нийт	75	8420	

- Стандартын лавлагаа, мэдээлэл

д/д	Стандартын төрөл	Стандарт	Иргэн	ААН
1	MNS	13	3	2
2	ISO	2	-	-
3	Нийт	15	3	2

- Цахилгаан хэмжих хэрэгслийн чиглэлээр

д/д	Цахилгааны хэмжил	1 фаз	3 фаз
1	Цахилгааны тоолуур	3	-
2	Нийт		3

- Эзлэхүүн зарцуулалтын чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Тоо /ш/
1	Шатахуун түгээгүүрийн шингэн хэжигч	-
2	Усны тоолуур	113
3	Шалгалт тохируулага	-
4	Авто цистерн	-
5	Нийт	113

- Механик, даралт, температурын чиглэлээр

д/д	Цулын хэмжил	Тоо ширхэг
1	Бүх төрлийн жин	34
2	Даралт температур	-
3	Авто пүү	-
4	Нийт	34

Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 1 дүгээр сард хийсэн ажлын тайлан

❖ Аймгийн Засаг даргын 2020 оны А/44 дугаар захирамжаар батлагдсан “Мэдээ тайлан ирүүлэх журам”-ын дагуу БОАЖГазрын 2020 оны үйл ажиллагааны тайлан, тайлангийн хавсралтуудыг гаргаж аймгийн ЗДТГ-ын ХШҮДОАХ, БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

❖ Байгууллагын жилийн эцсийн нийгмийн даатгалын тайлан, татварын тайлангуудыг тус байгууллагуудын холбогдох онлайн сайтаар бөглөж баталгаажууллаа. Байгууллагын 2020 оны санхүүгийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт баталгаажуулахаар хүргүүлээд байна. 2021 оны үйл ажиллагааны төсвийг сарын хувиараар хийж аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээр баталгаажууллаа.

❖ “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт”, Ус үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын үндэсний хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн биелэлтүүдийг гаргаж ЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖЯ-ны холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүллээ.

❖ 2021 оны байгууллагын орон тоо цалингийн санг газрын даргын 2021 оны Б/01 тушаалаар батлан мөрдөж ажиллаж байна.

❖ Албан хаагчдын зэрэг дэв олгох, ахиулах талаарх саналуудыг нэгтгэн аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.

❖ Байгууллагын архивт 2020 оны баримт бичгийг холбогдох мэргэжилтнүүдээс хүлээн авах ажлыг зохион байгууллаа. Үүнд 2020 оны Даргын А,Б тушаалууд, Ирсэн бичиг, Явсан бичиг, Өргөдөл, Үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөнүүд, Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүд, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн тайлан, санхүүгийн баримтууд, Уул уухайн компаниудын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангууд зэрэг холбогдох баримт бичгүүдийг үдэж, товъёоглон байгууллагын архивд шилжүүлсэн. Архивт байнга хадгалах 65, түр хадгалах 223, 70 жил хадгалах 39, нийт 311 баримт бичиг байна.

❖ Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар боловсруулан аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

❖ Монголын улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Мерит” төсөлтэй хамтран уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах тайлагнах”, “Уурхайн хаалтын журам”, “Байгаль орчны аудитын эрх олгох” журмын талаарх цахим сургалтыг 2021 оны 01 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын

